



ХӨДӨЛМӨРИЙН ЯАМНЫ ХАРЬЯА
БНСУ ДАХЬ НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ДАРГА М.НЯМДАВАА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.29 № 04/39 ЧАТ-САТ/2014/09/СМА-ТМЭЗ

Зөрчил арилгах тухай

Хөдөлмөрийн сайдын 2013 оны төсвийн багцын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Хөдөлмөрийн яамны харьяа БНСУ дахь нэг цэгийн үйлчилгээний төв 2013 оны батлагдсан төсөвт зардлыг Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалын дагуу бараа үйлчилгээний зардлын бүлэглэл хооронд зохицуулалт хийсэн боловч байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зардал 2.1 сая, эд хогшлын зардал 0.5 сая, бусад бараа үйлчилгээний зардал 8.9 сая төгрөгөөр тус тус бүлгийн дүнгээр хэтэрсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д: “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төсөвлөж, зарцуулах”, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан журмын 5 дугаар зүйлийн 5.4-д: “төсвийн байгууллага нь зардлын бүлгийн дүнд багтаан эдийн засгийн ангиллын дагуу зардал гаргах бөгөөд хугацаа хэтэрсэн өр, төлбөр үүсгэхгүйгээр хөтөлбөр, арга хэмжээний зорилтыг бүрэн хангахаар төсвийг зарцуулна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т: “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д “.....алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэж заасныг тус тус үндэслэн **Шаардах нь:**

1. Дээрх зөрчлийг таслан зогсоож, байгууллагын хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, зохих заавар, журмын дагуу зарцуулж байх
2. Албан шаардлагаар өгсөн үүргийн биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 30-ны дотор ҮАГ-т ирүүлэхийг Хөдөлмөрийн яамны харьяа БНСУ дахь Нэг цэгийн үйлчилгээний төвийн дарга М.Нямдаваа, нягтлан бодогч Л.Оюунсүвд нарт хариуцуулав.

АУДИТОР



П.ЧАНЦАЛДУЛАМ

УХА0122

Акт, албан шаардлага-А4 бланк